

**МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ
САНХҮҮЖИЛТ (ТoС)-ИЙН ЗАРЧИМ
ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЛБАРЫН УДИРДАМЖ**

2015 оны 2–р сар

АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	3
1. ТАНИЛЦУУЛГА	7
2. ЗОРИЛГО.....	7
3. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ БОЛОН ХАМРАХ ХҮРЭЭ	8
4. ХАА-Н САЛБАРЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН АСУУДАЛ.....	9
5. МОНГОЛ УЛСЫН ХАА-Н САЛБАРЫН ЗЭЭЛТЭЙ ХОЛБООТОЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ШААРДЛАГА	10
6. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ.....	13
7. ТАЙЛАГНАЛ.....	14
Хавсралт 1: ХАА-н салбарын үйл ажиллагаа, холбогдох байгаль орчин, нийгмийн асуудал.....	15
Хавсралт 2: ХАА-н салбарын холбогдох Монгол Улсын хууль тогтоомж	25
Хавсралт 3: ХАА-н салбарын холбогдох үндэсний болон олон улсын БОНХ- ын стандарт, шаардлага, зарчим болон бусад баримт бичиг	26
Хавсралт 4: ХАА-н салбарын оролцогч талуудын үүрэг, хариуцлага	28

Нэр томъёоны тайлбар

Товчлол/Нэр томъёо	Тодорхойлолт
Агро -ойжуулалт	Агро-ойжуулалт нь мод, бут сөөгийг тариан талбайд хамтад нь тарьж харилцан давуу тал бий болгож ашигтай үр дүнд хүрэх цогц арга зүй юм. Энэ нь хөдөө аж ахуй ба ойн аж ахуйн технологийг нэгтгэж илүү олон төрлийн, үр дүнтэй, ашигтай, эрүүл, тогтвортой газар ашиглах тогтолцоог бий болгодог юм. Агро-ойжуулалт нь явцуу утгаараа “тариалангийн талбайн мод” гэсэн үг юм
Зөгийн аж ахуй	Зөгийн аж ахуй нь балт зөгийн сүргийг ихэвчлэн хүний гараар бүтсэн зөгийн үүрэнд арчилж үржүүлэх үйл ажиллагаа юм. Зөгий үржүүлэгч нь зөгийн үүрнээс бал болон бусад дайвар бүтээгдэхүүн (зөгийн лав, зөгийн жилий, тоосонцор болон зөгийн сүүнцэр)-ийг гаргаж авах, тариалангийн ургамлуудад тоос хүртээх эсвэл зөгий үржүүлж бусад зөгий үржүүлэгчдэд зарах зэрэг зорилгоор зөгийн аж ахуйг эрхэлнэ
Усны аж ахуй	Усны аж ахуй нь загас, хавч хэлбэртэн, нялцгай биетэн ба усны ургамал гэх мэт усны организмыг үржүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Үүнд, цэнгэг усны болон давстай усны амьтдын популяцийг тусгай нөхцөл дор үржүүлэх явдлыг ойлгох бөгөөд энэ нь арилжааны зориулалтаар загас агнах үйл ажиллагаанаас ялгаатай юм. Учир нь загас агнуур бол загас барихыг хэлнэ
Банк	Банк гэдэгт Байгаль орчин, нийгэмд ээлтэй Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмын хамтарсан тунхаг бичигт гарын үсэг зурсан Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй банкийг ойлгоно.
Үндсэн үйл ажиллагаа	Банкнаас харилцагчдад үзүүлж буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж, тухайлбал, компанийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын банк (нөхцөл өөрчлөгдсөн зээл, хөрөнгө, худалдаа), өмчийн хөрөнгө оруулалт, төслийн санхүүжилт, бүтцийн худалдааны санхүүжилт, ЖДБ-ийн зээл, иргэдийн банк, худалдаа, лизинг, зээлийн бусад төрөл гэх мэт багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй юм
Дотоод үйл ажиллагаа	Банкнаас өөрийн үндсэн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай боловсон хүчин, өмч хөрөнгө болон дэд бүтэц (оффис, банкны салбар, тоног төхөөрөмж гэх мэт) багтана. Үүнд мөн банкнаас өөрийн үндсэн үйл ажиллагааг эрхлэх болон дотоод үйл ажиллагааг явуулахад хамтран ажиллаж буй ханган нийлүүлэгч, гэрээт байгууллага, гуравдагч үйлчилгээ үзүүлэгч талууд багтана
Монгол банк	Монгол Улсын Төв банк (Монгол банк)
Сүүний ферм	Сүүний ферм нь ихэвчлэн үнээ, ямаанаас гадна хонь, гүү, ингэ зэрэг амьтадыг хүний хэрэгцээнд зориулж саах үйл ажиллагаатай бизнесийг хэлнэ

Товчлол/Нэр томьёо	Тодорхойлолт
БОНХБНУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ нь төслийн тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай Байгаль орчинд нөлөөлөх байдлын илүү нарийвчилсан үнэлгээ (Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шаардлага) юм
Зуд	Зуд гэдэг нь өвлийн улиралд тохиолдох байгалийн гамшигт үзэгдэл бөгөөд мал ихэвчлэн бэлчээрлэх боломжгүй болсноор мөн хүйтний улмаас мал сүрэг олноор үхэж хорогдох үзэгдлийг нэрлэсэн Монгол үг юм
БОНХБҮ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь төлөвлөгөө, бодлого, хөтөлбөр эсхүл төсөл хэрэгжүүлэх шийдвэр гаргахаас өмнө байгаль орчинд үзүүлэх үр дагавар (эерэг, сөрөг)-ыг урьдчилан тооцож, нөлөөллийг хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүргэх арга хэмжээ санал болгож, шинэ технологийн шийдлийг судлах албан ёсны үйл ажиллагаа юм
БОХТ	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь хэрэгжүүлж буй төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй тодорхойлогдсон сөрөг нөлөөллүүдийн хяналт шинжилгээ болон бууруулах бүх арга хэмжээнүүдийг тусгасан төлөвлөгөө юм
БОНХ	Байгаль орчин, нийгмийн хариуцлага
БОНХ-ийн эрсдэл	Бизнес болон эрсдэлийн удирдлагын шийдвэр гаргах явцад анхаарах шаардлагатай харилцагчийн эрсдэл үүсгэж болзошгүй байгаль орчин, нийгмийн асуудал
БОНХ-ийн нөлөөлөл	Банкнаас санхүүжүүлж буй бизнесийн үйл ажиллагаанаас материаллаг, байгалийн болон соёлын орчин, түүнчлэн олон нийт, ажилчдад үүсэх бодит эсвэл болзошгүй өөрчлөлтүүдийг ойлгоно. Байгаль орчин, нийгмийн нөлөөллүүд нь байгаль орчин, хүн/олон нийтэд түр зуурын эсвэл байнгын шинжтэй, нөхөн сэргээгдэх эсхүл нөхөн сэргээгдэхгүй шинжтэй байж болно. Байгаль орчны нөлөөлөлд хүний үйл ажиллагаа (хүлэмжийн хий, бохирдол, амьдрах орчны өөрчлөлт гэх мэт)-наас үүдэлтэй уур амьсгалын, усны, газар нутгийн өөрчлөлтүүд багтана. Нийгмийн нөлөөлөлд тухайн харилцагчийн ажиллах хүч болон ойр орчмын олон нийт (эрүүл мэнд, аюулгүй байдал, хүний эрх болон хөдөлмөрийн нөхцөл, газрын маргаан/нүүлгэн шилжүүлэлт, авилга гэх мэт)-д нөлөөлөх нөлөөллүүд багтана
БОНХ-ийн шинэ боломж	Байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотойгоор үүсэх шинэ бизнесийн боломж (цэвэр/сэргээгдэх техник технологийг нутагшуулах, шинэ ажлын байр бий болгох, орон нутгийг хөгжүүлэх гэх мэт)-ийг ойлгоно. Бизнесийн шийдвэр гаргах явцад байгаль орчин, нийгмийн асуудлуудыг харгалзан авч үзэх нь харилцагч болон тухайн харилцагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй банкинд шинэ боломж нээж өгөх давуу талтай

Товчлол/Нэр томьёо		Тодорхойлолт
Хүнсний байдал	аюулгүй	Хүнсээр дамжин тархдаг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүнсийг хэрхэн бэлтгэх болон хадгалах тухай салбар шинжлэх ухаан юм
ТЭЗҮ		ТЭЗҮ нь төслийг нарийн тодорхойлох болон төслийн биелэлт эсхүл амжилттай хэрэгжих магадлалыг тооцохтой холбоотой авч үзэх шаардлагатай стратегийн асуудлуудыг тодорхойлох үйл ажиллагаа юм
МХЕГ		Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
Хувиргасан организм	амьд	Хувирсан амьд организм гэдэгт генийн инженерчлэлийн аргаар генийн түвшинд өөрчлөлт орсон организмыг хэлнэ. Хувирсан амьд организмд бактери, гэх мэт бичил биетнүүд мөн шавж, ургамал, загас, хөхтөн амьтан зэрэг багтана. ХАО нь генийн өөрчлөлттэй хоол хүнсний гол үүсвэр бөгөөд шинжлэх ухааны судалгаа болон хүнснээс гадна бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд мөн ашиглагддаг
Хүлэмж		Хүлэмж нь ургамал тарих зориулалттай байгууламж юм. Байгууламж нь хэмжээний хувьд янз бүр байдаг ба жижиг саравчаас үйлдвэрлэлийн хэмжээтэй барилгууд хүртэл байж болно. Жижиг хэмжээтэй хүлэмжийг хүйтэн хүлэмж гэж мөн нэрлэдэг
ЭЦАБХШТ		Эгзэгтэй цэгийн аюултай байдлыг хянан шинжлэх тогтолцоо (ЭЦАБХШТ) хүнсний аюулгүй байдлыг хангах болон эцсийн бүтээгдэхүүний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй боловсруулах процесс дэх биологи, хими, физикийн хор уршигаас системтэйгээр урьдчилан сэргийлэх мөн энэхүү эрсдлүүдийг аюулгүй түвшинд хүртэл буулгах арга хэмжээнүүдийг боловсруулах арга юм
ОУСК		Олон улсын санхүүгийн корпораци
Мал аж ахуй		Фермийн амьтдаас үр шимийг хүртэх зорилгоор арчилж маллах явцад тодорхой генетик шинж ба зан төрх нь хүний хувьд ашигтайд тооцогдвол цааш үржүүлж хөгжүүлэхийг үүнд ойлгоно. Энэ нь ашиг шим хүртэх, сонирхлын дагуу судалгааны зорилгоор тухайн амьтны тодорхой ашигтай шинж тэмдгийг сайжруулахын тулд селекци үржүүлгийн аргыг ашиглан мал сүргийг үржүүлэх ажил мөн хүнд ашигтай хөдөө аж ахуйн төрөл зүйлийг үр ашигтай ашиглах явдал юм. Мал аж ахуйн үйл ажиллагааг ерөнхийд нь фермийн болон бэлчээрийн гэж 2 ангилна
Бэлчээрийн аж ахуй		Бэлчээрийн мал аж ахуй нь 4 улирлын нүүдлийг дагаж үржил шимт бэлчээр хайж мал сүргийг хариулдаг мал аж ахуйн уламжлалт ажиллагаа

Товчлол/Нэр томьёо	Тодорхойлолт
Фермийн аж ахуй	Фермийн аж ахуй нь үр тариа ургуулахаас илүү мал өсгөн үржүүлэх зорилготой байдаг. Тухайлбал: сүү болон сүүн бүтээгдэхүүний ферм, махны чиглэлээр бод малыг, харин хонь, ямаа зэргийг ноос, ноолуур гаргах зорилгоор өсгөх гэх мэт
БОНХЯ	Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам
ҮХААЯ	Үйлдвэр, Хөдөө Аж Ахуйн Яам
ХААЭА	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Үүнд: ажил, хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалах асуудал хамаарна
Пестицид	Пестицид нь аливаа хортон шавж амьтныг татах, урхидах улмаар устгах буюу тоог цөөрүүлэх зориулалттай бодис юм. Пестицидийг голчлон ургамлыг (түүнчлэн үр тариа хамгаалах бүтээгдэхүүн гэгддэг) хөл газрын ургамал, ургамлын өвчин буюу шавж зэрэг сүйтгэх нөлөөнөөс хамгаалах бүтээгдэхүүн хэлбэрээр хэрэглэдэг
Гахайны ферм	Энэ ферм нь гахайг нядлах жинд хүртэл өсгөж үржүүлдэг аж ахуйн нэг төрөл юм
Шувууны ферм	Энэ ферм нь тахиа шувууны мах, өндөг зэргийг үйлдвэрлэхэд чиглэсэн хөдөө аж ахуйн салбар юм. Мөн үүнээс дайвар бүтээгдэхүүн болох тахианы өд гарах бөгөөд мах болон ясны тэжээл үйлдвэрлэхэд хэрэглэх үлдэгдэл түүхий эд, сангас зэргийг давхар гаргаж авдаг нь чухал органик бордоо болдог
Зарчмууд	МУ-ын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд
Бизнес/Ажлын төлөвлөгөө	Бизнесийн гол зорилго, энэ зорилгыг биелүүлэх боломжтой гэж үзэж буй шалтгаанууд болон зорилгоо биелүүлэхийн тулд хэрэгжүүлэх төлөвлөгөө зэргийг тусгасан албан ёсны бичиг баримт юм. Үүнд мөн уг бизнесийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх байгууллага эсхүл багийн тухай ерөнхий мэдээллийг тусгасан байж болно
Тогтвортой санхүүжилт (ТоС)	МУ-ын эдийн засгийн урт хугацааны хөгжилд, банкууд гагцхүү санхүүгийн ашиг сонирхлоор бус байгаль орчин, нийгэмд хариуцлагатай байдлаар оролцох үүрэг хариуцлагыг тодорхойлно

1. Танилцуулга

Энэхүү удирдамжийг дараах Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд (Зарчим)-ын дагалдах баримт бичиг болгон хөдөө аж ахуйн салбар, салбарын үйл ажиллагаанд зээл, хувьцааны санхүүжилт олгодог банкуудад зориулж боловсруулсан байна. Үүнд:

Зарчим 1 | Байгаль орчныг хамгаалах

Зарчим 2 | Ажилчид болон орон нутгийн иргэдийг хамгаалах

Зарчим 3 | Түүх, соёлын өвийг хамгаалах

Зарчим 4 | Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих

Зарчим 5 | Санхүүгийн үйлчилгээний тэгш хүртээмжийг дэмжих

Зарчим 6 | Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

Зарчим 7 | Хариуцлагатай, ил тод байдлыг дэмжих

Зарчим 8 | Манлайлан үлгэрлэх

Хөдөө аж ахуйн салбарын төслийг санхүүжүүлж, харилцагчдад зээл олгож буй банкууд шинэ харилцагч, төсөл, зээлийг үнэлэхдээ Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд болон энэхүү салбарын удирдамжийг мөрдөх шаардлагатай. Салбарын удирдамжийг Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудад нийцэж, эдгээрийн хэрэгжүүлэлтийг дэмжиж байхаар загварчилсан юм. Энэхүү Салбарын удирдамж нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагад гол төлөв анхаарлаа хандуулсан боловч банкууд харилцагчийнхаа эрсдэлийн удирдлагаас гадна байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг сайжруулах боломжийг харгалзан үзэх шаардлагатай.

2. Зорилго

Хөдөө аж ахуйн салбарын энэхүү удирдамж нь хөдөө аж ахуйн салбарын харилцагчдад зээл олгохтой холбоотойгоор үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, боломжийг үнэлэхэд нь банкуудад дэмжлэг үзүүлэх зорилготой. Удирдамжийг дараах үйл ажиллагааг дэмжих зорилгоор боловсруулсан. Үүнд:

- ХАА-н салбарын харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл, боломжийг тодорхойлохийг зэрэгцээ харилцагчийн байгаль орчин, нийгмийн асуудлуудыг (**Хавсралт 1, Хүснэгт 1**-ийг харна уу) удирдах чадварыг тодорхойлох;
- ХАА-н үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг зээл, харилцагчийн түвшинд үнэлж, ангилан байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний шалгуурыг бий болгох;
- ХАА-н салбарын харилцагчдад зээл, санхүүжилт олгохтой холбоотой үүсэх байгаль орчин, нийгмийн эрсдэлийг удирдан зохицуулах салбарын холбогдолтой олон улсын стандарт, тэргүүн түршлагыг авч хэрэгжүүлэх;
- ХАА-н салбарын харилцагчдад зээл, санхүүжилт олгох явцдаа ил тод байдал, хариуцлагыг дэмжих хандлагыг хэрэгжүүлэх;
- Шаардлагатай тохиолдолд, харилцагчийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг сайжруулах боломжийг тодорхойлно. Үүнд:
 - Мал аж ахуйн салбарын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах санаачлагыг дэмжих;

- Тогтвортой хөдөө аж ахуйн туршлага хэрэгжүүлж буй, органик хүнс, хууль ёсны худалдааны бүтээгдэхүүн зэрэг хөдөө аж ахуйн баталгаажсан тогтвортой бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төслийг дэмжих бодлого баримтлах;
- Хоол хүнсний ерөнхий тэжээлэг чанарыг сайжруулахын зэрэгцээ хүнсний аюулгүй байдал, хамгаалал зэрэг асуудлуудыг үндэсний түвшинд шийдэж буй төслийг дэмжих.

3. Хэрэгжүүлэлт болон хамрах хүрээ

Энэхүү удирдамжийг Зарчмуудыг авч хэрэгжүүлж буй Монгол Улсын банкууд дагаж мөрдөх бөгөөд ХАА-н салбарын харилцагч, хөрөнгө оруулж буй компаниудын үндсэн үйл ажиллагааг хамруулна. Удирдамжинд ХАА-н салбарын дараах үйл ажиллагаа багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

Агро-ойжуулалт;

Усны аж ахуй;

Үр тарианы аж ахуй;

Мал аж ахуй.

Салбарын үйл ажиллагаа	Дэд салбарын үйл ажиллагаа
Агро-ойжуулалт	<ul style="list-style-type: none"> • Газар тариаланг мод, бут сөөгтэй хослуулан тариалж ургуулах хөдөө аж ахуйн цогц аргачлал
Усны аж ахуй	<ul style="list-style-type: none"> • Загас, хавч, нялцгай биетэн болон усны ургамал зэрэг усны организмын аж ахуй
Үр тарианы аж ахуй	<ul style="list-style-type: none"> • Буудай болон тосны ургамалын тариалан: <ul style="list-style-type: none"> ◆ Усалгаатай газар тариалан; ◆ Усалгаагүй газар тариалан. • Хүлэмж (улаан лооль, өргөст хэмх, хүлэмжид ургадаг бусад хүнсний ногоо); • Төмс, лууван, байцаа, чацаргана, аньс, нэрс зэрэг задгай талбайн хүнсний ногоо, жимс жимсгэний тариалан
Мал аж ахуй	<ul style="list-style-type: none"> • Фермерийн аж ахуй: <ul style="list-style-type: none"> ◆ Зөгийн аж ахуй; ◆ Сүүн ферм; ◆ Шувууны ферм; ◆ Хонины ферм; ◆ Гахайн ферм. • Бэлчээрийн мал аж ахуй – гол төлөв адуу, тэмээ, үхэр, хонь, ямаа, буга зэрэг амьтадын маллагааны уламжлалт арга <ul style="list-style-type: none"> ◆ Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хадгалалт, боловсруулалт, худалдаа

Энэхүү удирдамжинд тусгасан байгаль орчин, нийгмийн эрсдэл нь хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор банкны харилцагч, түүний ханган нийлүүлэгчийн үйл ажиллагаанаас байгаль орчин, орон нутгийн иргэдэд учирч болзошгүй нөлөөлөл, эрсдэлд хамааралтай. **Хавсралт 1: Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа, холбогдолтой байгаль орчин, нийгмийн эрсдэл**-ийг харна уу.

4. ХАА-н салбарын байгаль орчин, нийгмийн асуудал

ХАА-н салбарын харилцагч, төсөлд санхүүжилт, зээл олгохдоо банк нь дараах нөхцлийг харгалзан байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үнэлэх шаардлагатай бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- ХАА-н салбарын үйл ажиллагааны төрөл болон цар хүрээ (том/үйлдвэрлэлийн хэмжээний эсвэл гэр бүлийн эзэмшлийн фермтэй эсэх) (**Хавсралт 1**-ийг харна уу);
- Байгалийн баялаг, тусгай хамгаалалтын газар нутаг, суурин газар, түүнтэй холбоотой эдийн засгийн үйл ажиллагаа, цаг уурын нөхцөл (хөдөө аж ахуйн төсөлд хүрээлэн буй орчны бодит нөхцөл, байгалийн гэнэтийн үзэгдэл/гамшиг зэрэг нь ихээхэн нөлөөтэй) зэргийг хамаарсан хөдөө аж ахуйн төслийн газарзүйн байршил; ба
- Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл (тухайлбал хөрсний доройтол, эвдрэл; биологийн олон янз байдлын хомсдол; ой мод сүйдэх; зэрлэг амьтдад халдварт өвчин тархах; хог хаягдал үүсэх; пестицид¹ ашигласнаас үүсэх агаар, ус, хөрсний бохирдол; хийн ялгарал, амьтадын эрүүл мэнд); эсвэл (хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй; орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, шувуу болон бусад амьтдад халдварт өвчний тархалт; газрын маргаан, нүүлгэн шилжүүлэлтийн асуудал; ажлын байрны хангалтгүй нөхцөл, ажлын уртасгасан цаг, хөдөлмөрийн гэрээгүй ажиллуулах, хүүхдийн хөдөлмөрийг ашиглах зэрэг хүний эрхийн зөрчил болон бүс нутгийн соёлын өв аюулд өртөх) зэрэг нийгэмд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл (**Хавсралт 1**-ийг харна уу).

Байгаль орчин, нийгмийн зарим асуудал нь эрсдэлийн өндөр түвшинд багтана. Доорхи хүснэгтэнд өндөр, дунд эрсдэлтэй зээлийн жишээг дурьдсан байна:

Эрсдэлийн түвшин	Нэмэлт мэдээлэл
Өндөр эрсдэлтэй үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд их хэмжээний, олон төрлийн, үл сэргээгдэх сөрөг эрсдэл, нөлөөлөл учруулж болзошгүй дараах үйл ажиллагааг хамааруулна.	<ul style="list-style-type: none"> • Монгол улсад ашиглахыг хориглосон химийн пестицид болон антибиотикийг их хэмжээгээр хэрэглэдэг ХАА-н үйл ажиллагаа; • Байгалийн өөрчлөгдсөн, чухал ач холбогдол бүхий амьдрах орчинд байрлах ХАА-ийн үйл ажиллагаа; • Ажлын байрны хөдөлмөрийн аюултай нөхцөлтэй ХАА-н үйл ажиллагаа; • Хүн, малын халдварт өвчин тараах өндөр эрсдэлтэй ХАА-ын үйл ажиллагаа; • Хүнсний аюулгүй байдлын эрсдэлтэй ХАА-н үйл ажиллагаа; • Боловсруулах боломжгүй их хэмжээний хог хаягдал үүсгэх ХАА-н үйл ажиллагаа; • Ус болон эрчим хүчний хэт хэрэглээтэй ХАА-н үйл ажиллагаа; • Хүүхдийн хөдөлмөр ашигласан ХАА-н үйл ажиллагаа (Гэр бүлийн мал аж ахуй, ферм үүнд багтахгүй болно); • Цаг агаарын өндөр эрсдэлтэй ХАА-н үйл ажиллагаа.
Дунд зэргийн эрсдэлтэй зээлийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд орон нутгийн шинж чанартай, бага хэмжээний, нөхөн сэргээгдэх боломжтой сөрөг эрсдэл /	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хангалтгүй гүйцэтгэлтэй хөдөө аж ахуйн үйл ажиллагаа; • Амьтан хамгаалахтай холбоотой эсэргүүцлийн жагсаал хийхэд хүргэж буй хөдөө аж ахуйн үйл ажиллагаа; • Хүн амын дийлэнх хэсгийг хамарсан эмх замбараагүй байдал, эсвэл

Эрсдэлийн түвшин	Нэмэлт мэдээлэл
нөлөөлөл учруулах үйл ажиллагаа багтана	<p>шүүхийн зарга үүсгэхэд хүргэж буй хөдөө аж ахуйн үйл ажиллагаа;</p> <ul style="list-style-type: none"> Бэлчээрийн малын тоог нэмэгдүүлснээр бэлчээрийн даацыг хэтрүүлснээр малчдын эсэргүүцэлтэй тулгарч буй хөдөө аж ахуйн үйл ажиллагаа; Ач холбогдолтой, урт хугацааны болон нөхөн сэргээгдэх байгаль орчны нөлөөлөл бүхий хөдөө аж ахуйн үйл ажиллагаа (Малын тоо толгой эсвэл хөрсний доройтолд хүргэдэг ямааны тоо толгой өссөний улмаас хүлэмжийн хийн ялгаралт нэмэгдэх).

5. Монгол Улсын ХАА-н салбарын зээлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн шаардлага

Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудын талаар авсан үүрэг амлалтандаа хүрэх, хөдөө аж ахуйн салбарын харилцагч, зээлтэй холбоотой БОНХ-ийн асуудлыг шийдвэрлэхийн тулд банк тус бүр өөрийн БОНХ-ийн удирдлагын тогтолцоог боловсруулж хэрэгжүүлнэ. Энэхүү БОНХ-ийн тогтолцоо нь ХАА-н салбарын БОНХ-ийн эрсдэлтэй холбоотой асуудлыг тодорхойлох, үнэлэх, шийдвэрлэх, байнгын мониторинг хийхэд нь банкинд туслах юм.

БОНХМС-ийн нэг хэсэг болгож банк нь хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагааг үнэлэхдээ холбогдох зарчмыг хэрэглэх нь зүйтэй юм. Ялангуяа, хөдөө аж ахуйн салбарын харилцагч, төсөл, зээлтэй холбоотой асуудлаар банкинд хамгийн их хамааралтай нь Зарчим 1: Байгаль орчныг хамгаалах, Зарчим 2: Ажилчид болон орон нутгийн иргэдийг хамгаалах, Зарчим 3: Түүх, соёлын өвийг хамгаалах Зарчим 4: Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих, Зарчим 5: Санхүүгийн үйлчилгээний тэгш хүртээмжийг дэмжих, Зарчим 6: Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих зэрэг юм.

Гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

Шаардлага	Нэмэлт мэдээлэл
1. Харилцагчийн (шаардлагатай тохиолдолд, гэрээт гүйцэтгэгчийн) хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой бичиг баримт болон зөвшөөрөлд анхан шатны шалгалт хийх	<p>Ерөнхий:</p> <p>Холбогдох төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл/лиценз (Хавсралт-3):</p> <ul style="list-style-type: none"> Байгууллагын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл; Малын эм бэлдмэл, тоног төхөөрөмж оруулж ирэх импортын тусгай зөвшөөрөл; Ургамал, ногоо хамгаалах химийн бодисуудыг импортлох, худалдаалах тусгай зөвшөөрөл. Төслийн/бизнесийн төлөвлөгөө; Бизнесийн нэгж нь дараах нөхцөлүүдийг хангасан байх шаардлагатай: <ul style="list-style-type: none"> Хүний нөөцийн чадавхи (гэр бүлийн буюу хөлсний ажилтнууд); Санхүүгийн чадавхи (Хөнөөлт шавж/өвчний халдвар, зуд, зах зээлийн үнэ буурах зэрэг хямралын үеийг даван туулах санхүүгийн нөөцийг баталсан бизнесийн үйл ажиллагааны бүхий л зардлын тооцоо); Бүтээгдэхүүн/хүнснийг аюулгүй хадгалах агуулах, барилга байгууламж

Шаардлага	Нэмэлт мэдээлэл
	<p>байгаа эсэх;</p> <ul style="list-style-type: none"> • Монгол Улсын эцсийн бүтээгдэхүүний зах зээлийн үнэтэй жишиж харьцуулсан бодит үнэтэй, чанартай түүхий эдээр хангах боломжийн үнэлгээ. • Төлөвлөгөөнд тухайн тариалангийн үйл ажиллагааг эрхлэхэд тохирсон хөрсний төрөл, өндөршил, цаг агаарын байдал, Монгол Улсын тариалан эрхлэлтийн ерөнхий нөхцөл зэрэг бусад хүчин зүйлсийг анхаарч үзсэн байх ёстой; • МХЕГ (Ажлын байрны дүгнэлт: ариун цэвэр, хүнсний аюулгүй байдал, ЭЦАБХШТ) бусад төрийн байгууллага (галын дүгнэлт)-ын зөвшөөрөл; • Тариалан, мал аж ахуйн эрсдэлээс шалтгаалсан нэмэлт барьцаа хөрөнгө байгаа эсэх; • Байгууллагын үйл ажиллагааны төрөл нь “Санхүүжүүлэхийг хориглох нэгдсэн жагсаалтад” байгаа эсэхийг шалгах; • Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчин, нийгэм, чанарын удирдлагатай холбоотой тухайн байгууллагын бодлого, үйл ажиллагаа, бүртгэл/бичиг баримт зэргийг шалгах. <p>Нарийвчилсан:</p> <ul style="list-style-type: none"> • Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу дараах төслүүд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хийлгэсэн байх шаардлагатай. Эдгээрт²: <ul style="list-style-type: none"> • Ан амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглах болон бусад үйл ажиллагаа; • Орон нутагт хэрэгжих агро-ойжуулалтын төсөл; • Усны аж ахуйн төсөл; • Үр тарианы үйлдвэрлэл эрхлэх талбай; • Ногоон байгууламж болон цэцэрлэгт хүрээлэн; • Хувиргасан амьд организмтай холбоотой үйлдвэрлэл болон үйлчилгээ; • Ан агнуур болон ойн аж ахуй; • Усалгаатай тариалангийн талбайн төсөл; • Үндэсний, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн орчимд хэрэгжих төсөл. • Үр тарианы аж ахуй: <ul style="list-style-type: none"> • Үр тариа ба төхөөрөмжийн даатгал (зуд зэрэг цаг агаарын эрс тэс нөхцөлийн эрсдлээс хамгаалах зорилгоор).

² <http://www.legalinfo.mn/law/details/8665?lawid=8665>

Шаардлага	Нэмэлт мэдээлэл
	<ul style="list-style-type: none"> • Мал аж ахуй: <ul style="list-style-type: none"> • Малын эрүүл мэнд, вакцинжуулалтын сертификат; • Хорио цээр болон бусад мал эмнэлгийн эрүүл ахуй, ариутгалын журам зааврыг дагаж мөрдөх; • Малын болон барилга/байгууламжийн даатгал (малын халдварт өвчний эрсдлээс хамгаалах зорилгоор); • Малын гаралтай хог хаягдлын гэрээ хэлэлцээр (өтөг, нядалгаанаас үүсэх хаягдал); хог хаягдлын төрөл болон аргачлал. • Худалдаа (ХАА-н хөрөнгийн биржээр): <ul style="list-style-type: none"> • Гарал үүслийн гэрчилгээ; • Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөл; • Барилга/байгууламж (агуулах), санхүү болон хүний нөөцийн хүчин чадлын баталгаа.
<p>2. Эрсдэлийг үнэлж ангилахдаа хөдөө аж ахуйн салбарын харилцагч, зээлийн БОНХ-ийн эрсдэлийн үнэлгээний тогтолцоог боловсруулах. Үнэлгээ, ангиллалын үр дүн нь харилцагчийн БОНХ-ийн эрсдлийн түвшинг тодорхойлж, зээл олголт, багцын удирдлага болон шийдвэр гаргахад чухал юм.</p>	<p>Хөдөө аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой өндөр болон дунд эрсдлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 4-с үзнэ үү.</p>
<p>3. Хөдөө аж ахуй салбарын зээл нь (хэмжээнээс хамааран) БОНХ-ийн холбогдох олон улсын болон үндэсний хууль тогтоомж, стандартын шалгуурыг хангаж буй эсэхийг үнэлэх (Хавсралт 2 болон 3-г харна уу)</p>	<ul style="list-style-type: none"> • Хөдөө аж ахуйн үйл ажиллагаанаас хамааран үндэсний заавал мөрдөх хууль тогтоомж, стандарт болон олон улсын сайн дурын үндсэн дээр дагаж мөрдөх стандартыг тодорхойлох; • Харилцагчийн гүйцэтгэлийг эдгээр хууль тогтоомж, стандартын дагуу дараах чиглэлээр хянана. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Байгаль хамгаалалын асуудал /үүгээр зөвхөн хязгаалагдахгүй/: • Байгаль орчны бохирдол; • Биологийн олон янз байдлын доройтол; • Хог хаягдлын удирдлага. • Нийгмийн хамгаалал /үүгээр зөвхөн хязгаалагдахгүй/:

Шаардлага	Нэмэлт мэдээлэл
	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн иргэдэд нөлөөлөх байдал; • Ажилчдад нөлөөлөх байдал. • Орхигдолыг тодорхойлж (БОНХ-ийн хамгийн их сөрөг эрсдэл), тэдгээрийг үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулах.
<p>4. БОНХ-ийн их хэмжээний эрсдэлтэй ХАА-н салбарын харилцагчийг тодорхойлж, эрсдэлийг зохицуулж, нөлөөллийг бууруулах харилцагчийн чадварыг үнэлэх</p>	<ul style="list-style-type: none"> • Харилцагчийн зүгээс авах удирдлага, нөлөөллийг бууруулах арга хэмжээ: <ul style="list-style-type: none"> • Эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх; • Талуудыг татан оролцуулах, гомдол барагдуулах өргөн хүрээтэй, үр нөлөөтэй механизмыг бий болгох (Хавсралт 4-г харна уу); • БОНХ-ийн болзошгүй эрсдэлийг 3-дагч этгээд хуваалцах зэрэг нөлөөлөл бууруулах арга хэмжээ авах

Өндөр болон дунд эрсдэлтэй зээлийг зөвшөөрөхөөс өмнө банк харилцагч нь өөрийн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан эсэхийг шалгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, харилцагч (гэрээт гүйцэтгэгч) өөрийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн хэмжээг бууруулах ажлуудыг багтаасан зохистой удирдлагын төлөвлөгөө, журамтай эсэхийг баталгаажуулна.

Хөдөө аж ахуйн салбарын харилцагчийн БОНХ-ийн гүйцэтгэл мүү, хангалтгүй байгаа тохиолдолд банк нь үйл ажиллагааны буюу ажлын төлөвлөгөө боловсруулж өгөхийг хүсэж болно. Төлөвлөгөө нь хэрэгжихүйц, тухайн цаг хугацаатай нийцсэн мөн баримтжсан байна. Банк нь БОНХ-ийн тодорхойлогдсон эрсдэлүүдийг харилцагч нь бууруулж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор уг нөхцөл, тохиролцоог зээлийн хэлцэлд оруулж өгөх бөгөөд зөрчил илэрсэн тохиолдолд харилцагч гэрээг биелүүлээгүй гэж үзнэ.

Дээрх асуудлуудыг дэмжих, нөгөө талаас банкны БОНУТ-ийн нэг хэсэг болгон банк тус бүр өөрийн холбогдох бизнесийн ажил үүргийн хуваарьт БОНХ-ийн эрсдэлийн удирдлагыг чадавхижуулах боломжийг эрэлхийлэх ба үүнд БОНХ-ийн эрсдэлийн сургалт, мэргэшсэн ажилтнуудыг авч ажиллуулж, сургалтанд хамруулах зэрэг асуудлууд багтана. Шаардлагатай тохиолдолд, банк нь БОНХ-ийн эрсдэлийн удирдлага болон сургалт явуулах зорилгоор шаардлага хангахуйц үр чадвартай хөндлөнгийн 3-дагч талыг татан оролцуулж туслалцаа авч болно. Гэхдээ энэхүү төрлийн дэмжлэг нь банкны өөрийн дотоод чадавхийг бэхжүүлэх чиглэлээр байж болохгүй.

6. Хяналт шинжилгээ

Байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй ХАА-н салбарын зээлийг батлахын өмнө банк нь тухайн компанийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хүрээнд тохирсон БОНХ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө; БОНХ-ын удирдлагын төлөвлөгөө; бусад шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавина.

7. Тайлагнал³

Банк нь өөрийн байгаль орчин, нийгмийн удирдлагын хэрэгжилтийн үйл явц, туршлага, ХАА-н салбарын харилцагч, түүний зээлийн түүхийн мэдээллийг багтаасан тайланг жилд нэг удаа Монгол банк болон Монгол Улсын банкны холбоонд ирүүлнэ (Хавсралт 4-г харна уу). ХАА-н харилцагчийн зээлийн үйл ажиллагааны тайланд дараах зүйлсийг тусгасан байна (үүгээр хязгаарлагдахгүй). Үүнд:

- ХАА-н салбарын үнэлж, зөвшөөрөгдсөн зээлийн тоо;
- ХАА-н салбарын үйл ажиллагаа, бүс нутгийн байршлаар харуулсан байгаль орчин, нийгмийн эрсдэлийн ангилал;
- Тогтмол хяналт шинжилгээ, үр дүн;
- Чадавхижуулах үйл ажиллагаа, талуудыг татан оролцуулах төлөвлөгөө, үр дүн.

DRAFT

³ Монгол улсын банкууд тайлагналын шаардлага дээр тохирсоны дараа эргэн хянана
Хөдөө аж ахуйн салбарын удирдамж

Хавсралт 1: ХАА-н салбарын үйл ажиллагаа, холбогдох байгаль орчин, нийгмийн асуудал

Хөдөө аж ахуйн салбарын харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой БОНХ-ийн асуудлын мөн чанар, төрөл нь хөдөө аж ахуйн үйл ажиллагааны төрөл, цар хүрээнээс хамаарна. ХАА-н компанийн БОННБҮ, БОНБНҮ-д дэлгэрэнгүй дурдсан БОНХ-ийн асуудлууд, түүнчлэн БОНХ-ийн эрсдэлийн үнэлгээ, ангилалын явцад хөндөгдөөгүй асуудлыг банк авч үзэх шаардлагатай. Харилцагч, түүний зээлийн БОНХ-ийн эрсдэлийн үнэлгээг хийхдээ ХАА-н үйл ажиллагаа, түүнтэй холбоотой дараах БОНХ-ийн асуудлыг харгалзан үзэх ёстой. Хүснэгт 1-д үзүүлсэн БОНХ-ийн асуудлууд үүгээр хязгаарлагдахгүй гэдгийг анхаарна уу.

Хүснэгт 1: Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа, холбогдох БОНХ-ийн асуудал

ХАА-н үйл ажиллагаа	Салбар үйл ажиллагаа	Салбар үйл ажиллагааны задаргаа	Байгаль орчны гол асуудлууд	Хяналт/удирдлага	Нийгмийн гол асуудлууд	Хяналт/удирдлага
Агро-ойжуулалт	<ul style="list-style-type: none"> Тариалалт Удирдлага Ургац хураалт Хадгалалт Худалдаа 	<ul style="list-style-type: none"> Ганцхан төрлийн ургац тариалалт нь биологийн олон янз байдлыг багасгах боломжтой Банз, гуалингийн өндөр эрэлтээс ой мод сүйдэх, Ойн шавж, хортоны тархалтаас үүдэн ой мод сүйдэх 	<ul style="list-style-type: none"> Биологийн олон янз байдал багасах явдлаас зайлсхийх (жишээ: унаган зүйл мод тарих, байнгын хяналт шинжилгээ хийх зэргийг багтаасан биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх) Ойн санг эзэмших журмыг⁴ дагаж мөрдөж, оролцоонд түшиглэсэн хууль бусаар мод огтлох үйл ажиллагааны хяналт шинжилгээг хэрэгжүүлэх Бага хор бүхий пестицид⁵ ашиглах, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хэрэглэж болох химийн пестицидийн зөвшөөрөл⁶ авах зэрэг Пестицидийн цогц удирдлагыг хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Хүний эрх – ажлын нөхцөл, ажлын уртасгасан цаг, хөдөлмөрийн гэрээгүй ажиллах зэрэг зөрчлүүд 	<ul style="list-style-type: none"> Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, хамтын гэрээ болон олон улсын Хүний эрхийн конвенцийг дагаж мөрдөх Ажлын байран дахь зөрчлийг⁷ ил гаргаж ирэх ажилчдын гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх 	

⁴ <http://www.legalinfo.mn/annex/details/4334?lawid=8325>

⁵ http://www.ifc.org/wps/wcm/connect/25356f8049a78eeeb804faa8c6a8312a/PS3_English_2012.pdf?MOD=AJPERES

ХАА-н үйл ажиллагаа	Салбар үйл ажиллагаа	Салбар үйл ажиллагааны задаргаа	Байгаль орчны гол асуудлууд	Хяналт/удирдлага	Нийгмийн гол асуудлууд	Хяналт/удирдлага
Усны аж ахуй		<ul style="list-style-type: none"> • Үржүүлэг • Удирдлага • Ургац хураалт • Хадгалалт • Тээвэрлэлт • Худалдаа 	<ul style="list-style-type: none"> • Зэрлэг байгальд тархаж болох өвчин • Ус болон хөрсний бохирдол • Биологийн олон янз байдлын болзошгүй хомсдол 	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх журмын шаардлагыг дагаж мөрдөх⁶ • Бохирдол үүсгэхээс зайлсхийх (ус, хөрсний байнгын хяналт шинжилгээ хийх зэргээр бохирдолоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр дамжуулан) • Биологийн олон янз байдал багасах явдлаас зайлсхийх (жишээ: биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах, унаган зүйл мод тарих, байнгын хяналт шинжилгээ хийх зэргийг багтаасан биологийн олон янз байдлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх) 	<ul style="list-style-type: none"> • Хүний эрх – ажлын нөхцөл, ажлын уртасгасан цаг, хөдөлмөрийн гэрээгүй ажиллах зэрэг зөрчлүүд • Хүнсний аюулгүй байдал⁹ 	<ul style="list-style-type: none"> • Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, хамтын гэрээ болон олон улсын Хүний эрхийн конвенцийг дагаж мөрдөх • Ажлын байран дахь зөрчлийг ил гаргаж ирэх ажилчдын гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх • Монгол Улсын Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийг дагаж мөрдөх

⁶ http://www.mne.mn/chemical/images/content/uploaded/zuvshuuru1_1204_50bd6d5bd07d8.htm

⁷ http://www.ifc.org/wps/wcm/connect/2408320049a78e5db7f4f7a8c6a8312a/PS2_English_2012.pdf?MOD=AJPERES

⁸ <http://www.legalinfo.mn/annex/details/5548?lawid=8349>

⁹ <http://www.legalinfo.mn/law/details/8911?lawid=8911>

ХАА-н үйл ажиллагаа	Салбар үйл ажиллагаа	Салбар үйл ажиллагааны задаргаа	Байгаль орчны гол асуудлууд	Хяналт/удирдлага	Нийгмийн гол асуудлууд	Хяналт/удирдлага
